101	Усан хангамж Ш 500 мм 1800 метр, Ш 80/300 мм-ийн 3080 метр, ариутгах татуургын Ш 300 мм 1050 метр, Ш 400/200 мм-ийн 1310 метр шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2017	1,510.0	565.9
102	Баянгол дүүрэг, Гандан Орхоны 10 дугаар гудамжны шинэчлэлт, барилгын ажил	2014	2017	381.6	30.9
103	Гандантэгчинлэн хийд орчмын гэр хорооллын нөхцөлийг сайжруулах дэд төслийн хүрээнд Орхоны 10 дугаар гудамжны зам барилгын ажил	2014	2017	182.0	138.8
104	Баянгол дүүрэг, Гандан Орхоны 5 дугаар гудамжны дэд бүтцийн ажил	2014	2017	655.8	28.3
105	Ирээдүй цогцолбор хорооллын дулааны 4100 метр гол шугам, 6 ширхэг дулаан дамжуулах төвийн зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2017	9,267.0	727.6
106	Яармагийн гүүр орчмын хорооллын 110/35/10 кВ-ын 2х25 МВА чадалтай компьютерийн хяналт, удирдлагын системтэй дэд станцын барилга угсралтын ажил, 110 кВ-ын АС-240/39 дамжуулагч утастай, 2х2 км шилэн кабель бүхий аянгын тросстой цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2017	7,291.0	5.7



107	Сонгинохайрхан дүүргийн 5, 6 дугаар хороо, Ханын материал орчмын гэр хорооллын дулааны 2 Ш 300/400 мм-ийн голчтой 1.1 км шугам, 1 ширхэг ус, дулаан дамжуулах төв, Ш 150 мм-ийн голчтой 137 метр шугам, бие даасан 9.3 Гкал чадалтай дулааны эх үүсвэр, гадна төв бохир усны Ш 500 мм-ийн 1235 метр шугам, бохир усны Ш 200-300 мм-ийн 1788 метр шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2018	9,854.0	987.3
108	Шархад, Амгалан орчмын бохир ус татан зайлуулах, ариутгах татуургын шугам сүлжээний ажил	2014	2017	2,224.0	343.4
109	220 кВ-ын Улаанбаатар дэд станцаас 14 дүгээр хорооллын дэд станц хүртэлх 110 кВ-ын 9.7 км, 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажил	2014	2017	938.4	311.9
110	110 кВ-ын Баянгол дэд станцаас 110 кВ-ын Радио телевиз дэд станц хүртэлх 110 кВ-ын 24 км, 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг, барилга угсралтын ажил	2014	2017	814.9	394.1
111	220 кВ-ын Сонгино дэд станцаас 110 кВ-ын Зайсан дэд станц хүртэлх 110 кВ-ын 50 км, 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг, барилга угсралтын ажил	2014	2017	2,139.7	583.9
112	110/35/10 кВ-ын 2х40 МВа дэд станцаас 14 дүгээр хорооллын дэд станцын 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам хүртэлх 110 кВ-ын 2 км, 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг, барилга угсралтын ажил	2014	2017	2,100.0	753.1
113	Сонгино 220/110/35 кВ-ын 2х125 МВа дэд станц, 220 кВ-ын 10 км цахилгаан дамжуулах агаарын шугам /Улаанбаатар/	2014	2017	4,698.0	1,182.7
114	Баянголын амны Баянгол хорооллын 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам 2.2 км, дэд станц, 110/35/10 кВ, 2х40 МВа /Улаанбаатар/	2014	2017	2,291.0	1,067.5
115	Баянголын амны 4 дүгээр ээлжийн дулааны ажил	2013	2017	2,925.8	126.7



116	Мардай-Чулуунхороот сумын 35 кВ-ын 160 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Дорнод/	2012	2017	4,397.4	346.5
117	Холбооны 2 яндантай 2100 метр сувагчлалын зураг төсөл, барилга угсралтын ажил	2015	2017	252.0	59.0
118	Амгалан дулааны станцын ахуйн хэрэгцээний цэвэр усан хангамжийн угсралтын ажил	2014	2017	228.0	9.9
119	Онцгой байдлын албаны командын байрын барилга, техник, тоног төхөөрөмж	2015	2017	20,000.0	33.7
НИЙТ ДҮН				1,012,951.7	172,794.9

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2017 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Нийгмийн даатгалын санд 2017 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хууль тогтоомж

2.1.Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль¹, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль², Нийгмийн даатгалын тухай хууль³, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

¹ Төсвийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 03 дугаарт нийтлэгдсэн.

² Төсвийн тогтвортой байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

³ Нийгмийн даатгалын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1994 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

ХОЁРДУГААР БҮЛЭГ
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2017 ОНЫ
ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын санд 2017 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	1,390,778.8
	1.1.Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх шимтгэл	514,316.3
	1.2.Ажиллагсдаас төлөх шимтгэл	518,780.7
	1.3.Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл	157,768.0
	1.4.Нөхөн олговор авагчийн нийгмийн даатгалын шимтгэл	0.3
	1.5.Цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл	52.0
	1.6.Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл	58,680.5
	1.7.Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл	59,352.7
	1.8.Эрүүл мэндийн даатгалын бусад даатгуулагчийн төлөх шимтгэл	27,326.8
	1.9.Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл	3,078.2
	1.10.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл	978.0
1.11.Бусад орлого	50,445.3	
2	Сангийн сайд	587,257.2
	2.1.Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	587,257.2
Нийт орлого		1,978,036.0

4 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	
	1.1.Тэтгэврийн даатгалын сан	1,404,356.2
	1.2.Тэтгэмжийн даатгалын сан	109,210.2
	1.3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	31,495.4



1.4.Ажилгүйдлийн даатгалын сан	29,719.1
1.5.Эрүүл мэндийн даатгалын сан	293,090.1
1.6.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны төлбөр	117.6
1.7.Үйл ажиллагааны урсгал зардал	19,420.1
Нийт зарлага	1,887,408.8

5 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн хуримтлалын сангаас Засгийн газрын урт хугацаат /нэг жил болон түүнээс дээш/ бонд худалдан авахад зарцуулах хөрөнгийн дээд хэмжээг 100,000.0 сая төгрөгөөр баталсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтын “1-12 сарын” гэснийг “12 сарын” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

МАЛЫН УДМЫН САН, ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1 дэх заалтын “1-12 хүртэлх сарын” гэснийг “12 сарын” гэж өөрчилсүгэй.



2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “1-12 хүртэлх сарын” гэснийг “12 сарын” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“30.2.Энэ хуулийн 24.1.1, 24.1.2-т заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн жинхэнэ албан хаагчид үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно. Нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь 36 сарын үндсэн цалингийн дунджаас хэтрэхгүй байна. Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох цалингийн дундаж хэмжээ болон олгох шалгуур нөхцөлийг тодорхойлсон журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.27, 4.1.28 дахь заалт:

“4.1.27. “үүсмэл орд” гэж олборлолт, боловсруулалт, баяжуулалтын явцад ялгагдсан ашигт малтмалын тодорхой агуулга бүхий дахин боловсруулахад эдийн засгийн үр ашиг гаргаж болохуйц хүдэр, ашигт малтмалын овоолгыг;

4.1.28. “үүсмэл орд ашиглах” гэж энэ хуулийн 4.1.27-д заасан хүдэр, ашигт малтмалын овоолго зэргээс ашигт малтмал ялган авах, боловсруулах, баяжуулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг.”

2/9 дүгээр зүйлийн 9.1.14, 9.1.15 дахь заалт:

“9.1.14. үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагааны журмыг батлах;”

9.1.15. үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмыг батлах.”

3/26 дугаар зүйлийн 26.10, 26.11 дэх хэсэг:

“26.10. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч гуравдагч этгээдэд үүсмэл ордыг ашиглуулах тохиолдолд уг гуравдагч этгээдтэй үүсмэл орд ашиглах тухай гэрээ байгуулж, энэ гэрээний талаар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад 14 хоногийн дотор мэдэгдэнэ.

26.11. Энэ хуулийн 26.10-д заасан гэрээ, үүсмэл ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн дүгнэлт, шийдвэрийг үндэслэн геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрлийг гурван жилийн хугацаатайгаар олгоно.”

4/47³ дугаар зүйл:

“47³ дугаар зүйл. Үүсмэл ордоос олборлосон ашигт малтмалын бүтээгдэхүүнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

47³.1. Үүсмэл ордоос олборлосон бүтээгдэхүүнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ тухайн бүтээгдэхүүний

борлуулалтын үнэлгээний 2.5 хувь, энэ хуулийн 47.5-д заасан нэмэлт төлбөрийн хэмжээ 0 хувьтай тэнцүү байна.

47³.2.Энэ хуулийн 47³.1-д заасныг үл харгалзан алтанд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийг энэ хуулийн 47.4, 47.5-д заасны дагуу ногдуулна.

47³.3.Энэ хуулийн 47³.1, 47³.2-т заасан борлуулалтын үнэлгээг энэ хуулийн 47.2-т заасан зарчмаар тодорхойлно.”

5/48 дугаар зүйлийн 48.13, 48.14 дэх хэсэг:

“48.13.Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч дараа жилийн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтүүд ажлын төлөвлөгөөг энэ хуулийн 48.6.2-т, тухайн жилийн ажлын тайланг 48.1.2-т заасан хугацаанд геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

48.14.Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 47³ дугаар зүйлд заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайланг энэ хуулийн 48.9-т заасны дагуу татварын албанд тушааж 48.10-т заасны дагуу холбогдох мэдээллийг нийтэд мэдээлнэ.”

6/53 дугаар зүйлийн 53.6 дахь хэсэг:

“53.6.Тусгай зөвшөөрөл дуусгавар болсон талбайд үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохыг хориглоно.”

2 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.7 дахь хэсгийн “ашиглалтын тусгай зөвшөөрөл” гэсний дараа “болон үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл” гэж, 56 дугаар зүйлийн 56.7 дахь хэсгийн “ашиглалтын” гэсний дараа “болон үүсмэл орд ашиглах” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.23 дахь заалтын “үүсмэл ордын” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:



1/9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэг:

"9.6.Энэ хуулийн 9.1.6-9.1.8-д заасан тусламж, үйлчилгээний зардлын төлбөр энэ хуулийн 6.1.4-т заасан даатгуулагчид хамаарахгүй."

2/14¹ дүгээр зүйл.Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн

"14¹.1.Эрүүл мэндийн даатгалын удирдах дээд байгууллага нь Үндэсний зөвлөл байна.

14¹.2.Үндэсний зөвлөл нь дараахь бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ажлаа Улсын Их Хуралд жил бүр тайлагнана:

14¹.2.1.Засгийн газрыг төлөөлж санхүү, төсвийн, нийгмийн даатгалын, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тус бүр нэг хүн;

14¹.2.2.даатгуулагчийн олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагыг төлөөлсөн гурван хүн;

14¹.2.3.ажил олгогчийн олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагыг төлөөлсөн гурван хүн.

14¹.3.Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал таван жилийн хугацаагаар томилж, чөлөөлөх бөгөөд нэг удаа улируулан томилж болно.

14¹.4.Үндэсний зөвлөлийн дүрмийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо батална.

14¹.5.Үндэсний зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг Нийгмийн даатгалын тухай хуулийн 27.2.3-т заасан ажлын алба хэрэгжүүлнэ.

14¹.6.Үндэсний зөвлөлийн гишүүнд ажлын оролцоог харгалзан улирал тутам урамшуулал олгох бөгөөд урамшууллын дээд хэмжээг нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо тогтооно."

3/14 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн 8-11 дэх заалт:

"14.9.8.энэ хуулийн 9.1-д заасан Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орох тусламж, үйлчилгээний жагсаалтыг эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах;

14.9.9.даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын Эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн дээд хязгаар, энэ хуулийн 11.2-т заасан даатгуулагчийн төлөх төлбөрийн хэмжээг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тухай бүр тогтоох;



14.9.10.Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоох;

14.9.11.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмыг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах."

2 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалтын "үйл ажиллагааг" гэсний дараа "энэ хуулийн 14.9.11-д заасан журмын дагуу" гэж, мөн зүйлийн 16.1.6 дахь заалтын "энэ хуулийн 14.9.1," гэсний дараа "14.9.8-14.9.11-д" гэж, 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалтын "эмчилгээний" гэсний дараа "болон санхүүгийн" гэж, 20 дугаар зүйлийн 20.1.9 дэх заалтын "зөвлөлийн гишүүний" гэсний дараа "энэ хуулийн 14'1.6-д" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтын "Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл" гэснийг "Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл" гэж, 8 дугаар зүйлийн 8.2.2, 8.2.4 дэх заалтын "улирал бүр" гэснийг "хагас жил" гэж, 14 дүгээр зүйлийн 14.9.8 дахь заалтын дугаарыг "14.9.12" гэж, 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалтын "нийгмийн даатгалын байгууллагаас" гэснийг "эрүүл мэндийн байгууллагаас" гэж, 20 дугаар зүйлийн 20.1.9 дэх заалтын "нэмэгдэл цалин" гэснийг "урамшуулал" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтын "эрүүл мэндийн даатгалын байгууллагад" гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн "Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан" гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь зүйл, заалт нэмсүгэй:



1/5 дугаар зүйлийн 5.4.40 дэх заалт:

“5.4.40.Спортыг дэмжих сан;”

2/5 дугаар зүйлийн 5.4.41 дэх заалт:

“5.4.41.Эрүүл мэндийг дэмжих сан.”

3/6 дугаар зүйлийн 6.4.22 дахь заалт:

“6.4.22.Спортыг дэмжих сан;”

4/6 дугаар зүйлийн 6.4.23 дахь заалт:

“6.4.23.Эрүүл мэндийг дэмжих сан.”

5/21⁷ дугаар зүйл:

“21⁷ дугаар зүйл.Спортыг дэмжих сан

21⁷.1.Спортыг дэмжих сангийн хөрөнгө нь энэ хуулийн 7.1-д заасан нийтлэг эх үүсвэрээс бүрдэнэ.

21⁷.2.Энэ хуулийн 21⁷.1-д заасан сангийн хөрөнгийг доор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

21⁷.2.1.нийтийн биеийн тамир, хүн амын идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээ;

21⁷.2.2.өндөр зэрэглэлийн тамирчин, дасгалжуулагчийг шинжлэх ухааны үндэслэлтэй бэлтгэх, хөгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх;

21⁷.2.3.үндэсний спортын төрлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

21⁷.2.4.үндэсний хэмжээний тэмцээн, наадмын сэргээшийн эсрэг хяналтыг хэрэгжүүлэх, сэргээшийн эсрэг үйл ажиллагааны сургалт, сурталчилгааг зохион байгуулах.

21⁷.3.Спортыг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах журмыг Засгийн газар батална.”

6/21⁸ дугаар зүйл:

“21⁸ дугаар зүйл.Эрүүл мэндийг дэмжих сан

21⁸.1.Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө нь энэ хуулийн 7.1-д заасан эх үүсвэр, архи, согтууруулах ундааны онцгой албан татварын 1 хувь, эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувь болон тамхины онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хөрөнгөөс бүрдэнэ.

21⁸.2.Энэ хуулийн 21⁸.1-д заасан сангийн хөрөнгийг дараахь чиглэлээр эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

21⁸.2.1.халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх;

21⁸.2.2.халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;

21⁸.2.3.орчны эрүүл мэндийг хамгаалах;

21⁸.2.4.осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй амьдралын орчныг бүрдүүлэх;

21⁸.2.5.сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, архи, тамхи, мансууруулах бодисын хорт нөлөөллөөс сэргийлэх;

21⁸.2.6.эмийн зохистой хэрэглээ;

21⁸.2.7.эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрүүл мэндийн байгууллагын ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх.

21⁸.3.Энэ хуулийн 21⁸.1-д заасан сангийн хөрөнгийг нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй болгох чиглэлээр хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын үр дүнтэй санаачилга, төсөл, хөтөлбөрийг дэмжих, урамшуулах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулж болно.

21⁸.4.Энэ хуулийн 21⁸.1-д заасан сангийн хөрөнгийг нийгмийн эрүүл мэнд, анагаах ухаан, эрүүл мэндийн шинжлэх ухааны дэвшилтэт технологийг эзэмшүүлэх зорилгоор эмнэлгийн мэргэжилтнийг гадаадад сургах, мэргэшүүлэх үйл ажиллагааг дэмжих арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулж болно.

21⁸.5.Эрүүл мэндийг дэмжих сангийн дүрэм, хөрөнгийг зарцуулах журмыг Засгийн газар батална.”

7/34 дүгээр зүйл:

“34 дүгээр зүйл.Хуулийг дагаж мөрдөх журам

“34.1.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “Эрүүл мэндийн даатгалын сан, Ирээдүйн тэтгэврийн нөөц сан,” гэснийг, 5 дугаар зүйлийн 5.4.36, 5.4.39 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.2.10, 6.2.12 дахь заалтыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.”

2 дугаар зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “6.4.6” гэсний өмнө “6.4.4,” гэж, “6.4.10” гэсний дараа “, 6.5.3” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтын “5.4.33” гэсний дараа “5.4.40, 5.4.41” гэж тус тус нэмсүгэй.



3 дугаар зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.12 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалт, 15 дугаар зүйлийн гарчиг, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, мөн зүйлийн 15.1.1 дэх заалтын “урлаг хөгжүүлэх” гэснийг “урлагийг дэмжих” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/14 дүгээр зүйлийн 14.2.11, 14.2.12 дахь заалт:

“14.2.11.төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах;

14.2.12.эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох.”

2/14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсэг:

“14.6.Энэ хуулийн 14.2.11-т заасан чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийх, чиг үүргийг дахин хуваарилах аргачлалыг Засгийн газар батална.”

3/16 дугаар зүйлийн 16.5.9 дэх заалт:

“16.5.9.дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын

ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох.”

4/45 дугаар зүйлийн 45.1.4-45.1.6 дахь заалт:

“45.1.4.техник, технологийн өөрчлөлт хийх зэргээр барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардлыг бууруулснаас бий болсон үлдэгдэл;

45.1.5.энэ хуулийн 14.2.12, 16.5.9-т заасны дагуу зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн тогтоосны улмаас орон тоо буурсан бол түүнд ногдох цалин хөлс, бусад урсгал зардлын үлдэгдэл;

45.1.6.төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээг хүрэх үр дүн чанарыг нь бууруулахгүйгээр илүү үр ашигтай, оновчтой хувилбараар зохион байгуулснаар бий болсон үлдэгдэл.”

5/71 дүгээр зүйлийн 71.5 дахь хэсэг:

“71.5.Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.6 дахь хэсэг, мөн зүйлийн 8.6.3 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.6.1 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг, 42 дугаар зүйлийн 42.3.3 дахь заалтын “төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.8, 8.9 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтын “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв,” гэснийг, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв болон Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн” гэснийг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.”

2 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсгийн “42.7” гэсний дараа “, 46.5” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“46 дугаар зүйл. Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах журам

46.1.Төсвийн захирагч төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг төсвийн үр ашгийг сайжруулах зорилгоор тухайн төсвийн жилд захиран зарцуулж болно.



46.2.Энэ хуулийн 46.1-д заасан төсвийг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

46.3.Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн дараахь арга хэмжээнд зарцуулж болно:

46.3.1.эх үүсвэр дутагдаж байгаа, эсхүл өр төлбөр үүссэн үндсэн үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжүүлэх;

46.3.2.байгууллагын хамт олон, ажилтныг ажлын үр дүнг нь харгалзан урамшуулах;

46.3.3.нийт ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх;

46.3.4.тухайн салбар болон байгууллагын үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий хөрөнгө оруулалт хийх.

46.4.Энэ хуулийн 46.3.2, 46.3.3-т заасан урамшууллыг хуваарилах асуудлыг байгууллагын нийт ажилтныг оролцуулсан хамт олны хурлаар хэлэлцэн, шийдвэрлэх бөгөөд хамт олны хурлын тэмдэглэл болон шийдвэрийг үндэслэн тухайн шатны төрийн сан зарцуулах эрх олгоно.

46.5.Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг дараахь арга хэмжээнд зарцуулахыг хориглоно:

46.5.1.байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах дараахь тохиолдолд:

46.5.1.а.ажилтны цалин хөлсийг хуульд заасан хугацаанд олгох боломжгүй байдалд хүрсэн;

46.5.1.б.төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулсан.

46.5.2.төсвийн жилд, эсхүл дараалсан хоёр улирлын төсвийн гүйцэтгэлийн тайлангаар өр төлбөр үүсгэх;

46.5.3.зочин төлөөлөгч хүлээн авах, гадаад томилолтын зардлыг санхүүжүүлэх;

46.5.4.байнгын орон тоо, шинэ бүтэц бий болгох замаар урсгал зардал нэмэгдүүлэх.”

4 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсгийн “47.1.5,” гэснийг хассугай.

5 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.4 дэх заалт, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1.6 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



6 дугаар зүйл. Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

**ИРЭЭДҮЙН ТЭТГЭВРИЙН НӨӨЦ
САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “2017 оны” гэснийг “2019 оны” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

**АХМАД НАСТНЫ НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.4, 6.5 дахь хэсэг:

“6.4.Билгийн тооллын хаврын тэргүүн сар-цагаан сар, Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярыг тохиолдуулан Монгол Улсын дараахь насны иргэнд доор дурдсан хэмжээгээр насны хишгийг жилд хоёр удаа олгоно.

6.4.1.65-69 настай ахмад настанд тавин мянган төгрөг;

6.4.2.70-79 настай ахмад настанд наян мянган төгрөг;

6.4.3.80-89 настай ахмад настанд нэг зуун тавин мянган

төгрөг;

6.4.4.90 ба түүнээс дээш настай ахмад настанд хоёр зуун

тавин мянган төгрөг.



6.5.Насны хишиг олгох журмыг Засгийн газар батална.”

2 дугаар зүйл.Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн гарчгийн “хүндэтгэл” гэсний дараа “, насны хишиг” гэж, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “5.1.8-5.1.10” гэсний дараа “, 6.4” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийгмийн халамжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалт:

“3.1.11.”босго шугам” гэж нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас энэ хуулийн 29.1-д заасан мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн өрхийг амьжиргааны түвшингээр эрэмбэлж оноо өгөх байдлаар тогтоосон хязгаарыг.”

2/13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалт:

“13.1.5.хүүхдийн мөнгөн тэтгэмж.”

3/13 дугаар зүйлийн 13.11, 13.12 дахь хэсэг:

“13.11.Энэ хуулийн 13.2.4-т заасан ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг тодорхойлох шалгуур үзүүлэлт, өвчин, гэмтлийн жагсаалтыг эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

13.12.Энэ хуулийн 13.1.5-д заасан хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журмыг Засгийн газар батална.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Авлигын эсрэг хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсгийн “12” гэснийг “36” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн Тэтгэмжийн даатгал-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний “0.8” гэснийг “1.0” гэж, мөн зүйлийн 5 дахь хэсгийн “3 хүртэл” гэснийг “2.8 хүртэл” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 42.3 дахь хэсэг нэмсүгэй:

“42.3. Төсвийн байгууллагаас энэ хуулийн 42.1-д заасан нэг удаагийн тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан нийтлэг журмыг Засгийн газар батална.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг нэмсүгэй:

1/15 дугаар зүйлийн 15.12 дахь хэсэг:

“15.12.Ерөнхий боловсролын тусгай сургуулийн суралцагчийн үдийн хоолны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үдийн хоолоор үйлчлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.”

2/32 дугаар зүйлийн 32.8 дахь хэсэг:

“32.8.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр орон нутгийн харьяалал харгалзахгүйгээр үнэ төлбөргүй зорчино. Энэ арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг нийслэл, орон нутгийн төсөвт жил бүр тусган, хэрэгжүүлнэ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “2021 оны” гэснийг “2017 оны” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9¹ дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9¹.3.4 дэх заалт нэмсүгэй:

“9¹.3.4.тухайн жилийн төсвийн алдагдлыг нөхөх.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Шүүхийн захиргааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “бүтэц, зохион байгуулалтаа” гэсний өмнө “батлагдсан төсвийн хүрээнд” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 28.11 дэх хэсэг нэмсүгэй:

“28.11.Энэ хуулийн 28.10-т заасан албан тушаалын цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрт Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын Ерөнхий прокурор, Улсын Ерөнхий прокурорын орлогч хамаарахгүй.”

2 дугаар зүйл.Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.11 дэх хэсгийн дугаарыг “28.12” гэж, 28.12 дахь хэсгийн дугаарыг “28.13” гэж тус тус өөрчилсүгэй.



3 дугаар зүйл.Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

**АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.10.22 дахь заалт нэмсүгэй:

“15.10.22.үүсмэл орд ашиглах.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

**УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.1.11 дэх заалт нэмсүгэй:

“25.1.11.үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгох, сунгахад тус бүр 5 000 000 төгрөг.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2 дахь заалтын “ашигт малтмалын”, 60 дугаар зүйлийн 60.2.6 дахь заалтын

“ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос” гэсний өмнө “Ашигт малтмалын тухай хуулийн 47³ дугаар зүйлд зааснаас бусад” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.4 дэх хэсэг нэмсүгэй:

“7.4.Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.27-д заасан үүсмэл ордоос олборлосон ашигт малтмалын бүтээгдэхүүнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг энэ хуулийн 7.1.4-т заасан орлогын эх үүсвэрт хамааруулахгүй.”

2 дугаар зүйл.Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын “47 дугаар зүйлд заасны дагуу” гэснийг “4.1.27-д зааснаас бусад орд ашигласнаас” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг нэмсүгэй:

1/14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг:

“14.2.Ашигт малтмалын үндсэн ордыг ашиглах зорилгоор олгосон энэ хуулийн 14.1.4-т заасан татварын тогтворжуулалтад үүсмэл ордоос



олборлосон ашигт малтмалын бүтээгдэхүүнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хамаарахгүй."

2/20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэг:

"20.7.Энэ хуулийн 20.4-т заасан тогтворжуулах татварын төрөлд энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасныг ойлгоно."

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2017 ОНЫ
ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2018-2019 ОНЫ
ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай:

	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2017 он	2018 он	2019 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	3.0	5.1	7.1
2	Хэрэглээний үнийн индексийн түвшин	6.5	7.6	8.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	6,160.2	6,822.6	7,561.3
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	23.3	23.8	23.7
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	8,568.9	8,971.2	9,316.5
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	32.3	31.3	29.2
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	-1,125.5	402.3	345.3
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-4.2	1.4	1.1
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-2,408.7	-2,148.6	-1,755.2
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-9.1	-7.5	-5.5



7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	1,483.9	1,517.6	1,540.6
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	5.6	5.3	4.8
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	22,363.7	22,889.5	23,903.1
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	84.4	79.9	74.9
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	467.3	490.7	623.0
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	1.8	1.7	2.0

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Дугаар 63

Улаанбаатар
хот

**Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох талаар авах зарим
арга хэмжээний тухай**

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 0-18 насны хүүхэд бүрд олгох мөнгөн тэтгэмжийг дараахь байдлаар зохион байгуулж олгохыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасгай:

1/Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.11-д заасан босго шугамаас доогуур эрэмбэлэгдсэн өрхийн хүүхэд бүрд 2017-2019 онд сар бүр бэлэн мөнгөөр олгох;

2/энэ тогтоолын 1 дэх заалтын 1-д зааснаас бусад хүүхдэд 2019 оноос эхлэн нөхөж олгох;

3/энэ тогтоолын 1 дэх заалтын 2-т заасан нөхөж олгох хүүхдийн мөнгөн тэтгэмжийн эх үүсвэрийг тухай бүр үе шаттайгаар Засгийн газрын үнэт цаас гарган бүрдүүлэх.

2. Энэ тогтоолыг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар
хот

“Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоолын хавсралтын 4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай дараахь заалт нэмсүгэй:

“4.20.”Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” хувьцаат компанийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах.”

2.“Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоолын хавсралтын 4 дэх хэсгийн 4.15 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“4.15.”Монгол шуудан” хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг худалдах;”

3.Төрийн өмчийг 2017-2018 онд хувьчлах үндсэн чиглэлийг Улсын Их Хурлаар батлах хүртэл төрийн өмчийг хувьчлах ажлыг Монгол Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоолоор баталсан Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийн дагуу үргэлжлүүлэн зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т зөвшөөрсүгэй.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Д.Тэрбишдагва/-нд үүрэг болгосугай.

5.Энэ тогтоолыг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Дугаар 65

Улаанбаатар
хот

Прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэг, Прокурорын байгууллагын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1.Монгол Улсын прокурорын байгууллагын прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2011 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 54 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

Монгол Улсын Их Хурлын 2016 оны
65 дугаар тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН
ПРОКУРОРЫН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ**

	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн хэмжээ /төгрөгөөр/
1	Монгол Улсын Ерөнхий прокурор	2 211 000
2	Улсын Ерөнхий прокурорын орлогч	2 080 000
3	Улсын Ерөнхий прокурорын туслах	1 980 000
4	Улсын Ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор	1 825 000
5	Нийслэлийн прокурор	1 950 000
6	Нийслэлийн прокурорын орлогч	1 875 000
7	Нийслэлийн прокурорын туслах	1 800 000
8	Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор	1 769 000
9	Аймаг, Тээврийн прокурор	1 920 000
10	Аймаг, Тээврийн прокурорын орлогч	1 850 000
11	Аймаг, Тээврийн прокурорын туслах	1 800 000
12	Аймаг, Тээврийн прокурорын газрын хяналтын прокурор	1 740 000
13	Дүүргийн прокурор	1 820 000
14	Дүүргийн прокурорын орлогч	1 800 000
15	Дүүргийн прокурорын туслах	1 780 000
16	Дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор	1 730 000
17	Сум дундын прокурорын газрын ахлах прокурор	1 820 000
18	Сум дундын прокурорын газрын хяналтын прокурор	1 730 000

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 11 дүгээр

Улаанбаатар

сарын 10-ны өдөр

Дугаар 66

хот

**Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүний
албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай**

Төрийн албаны тухай хуулийн 28¹ дүгээр зүйлийн 28^{1.2} дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүний албан тушаалын цалингийн хэмжээг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Үндсэн хуулийн цэцийн гишүүний албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн



тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2008 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 46 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

Монгол Улсын Их Хурлын 2016 оны
66 дугаар тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА,
ГИШҮҮНИЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ**

№	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн хэмжээ /төгрөгөөр/
1	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга	3 300 000
2	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн	3 250 000

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Дугаар 67

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүний төрийн
алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээг шинэчлэн
тогтоох тухай**

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.3 дахь заалт, 28.7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Үндсэн хуулийн цэцийн гишүүний төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээг албан тушаалын сарын цалингийн 10 хувиар тогтоосугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2001 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 74 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 5.5

Индекс: 14003